

**МОНГОЛ УЛС, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН “УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ, ТОГТВОРТОЙ МАЛ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ”
ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 03 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх” төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр ирүүлсэн билээ.


Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа дээрх төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Цэрэнпунцаг, М.Оюунчимэг, С.Чинзориг, Х.Булгантуяа, Д.Бат-Эрдэнэ нар шинээр зээл авах тохиромжгүй байгаа талаар, эрсдэлийн удирдлагаараа энэ зээлийнхээ нөхцөл байдлыг дахиж тодорхойлон эцэслэж байж Засгийн газрын өрийг нэмэх, Эдийн засгийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй байнгын хороо, Төсвийн байнгын хорооноос энэ зээлийн гэрээний зориулалт дээр чиглэл өгч, зарим нэг өөрчлөлтүүдийг хийх, төслийн зорилгыг уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол, цөлжилт хамгийн их явагдсан бүс нутаг болох говийн бүсийн нутгуудад болон уул уурхайн бүтээгдэхүүнийг олборлож байгаа нутгуудад чиглүүлэх талаар анхаарах, төслийн техник эдийн засгийн үндэслэл дээр анхаарах талаар үг хэлж, асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх” төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжээгүй санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ж.ГАНБААТАР